



АУДИТЫН КОД: САГ-2017/06/СТА-ТЕЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням

Утас: 260512 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn

Аудитор Н.Золзаяа

Утас: 260512 Цахим хаяг: zolzayan@audit.gov.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	6
2.5	Дотоод хяналт	7
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	7
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	8
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	8
2.9.1	Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, баримтын бүрдэл хангах талаар	8
2.9.2	Урьдчилж төлсөн зардлаар бүртгэх талаар	9
2.9.3	Ажиллагсадтай холбоотой өр төлбөрийн талаар	9
2.10	Анхаарал татахуйц бусад асуудал	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	9
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал.....	11
3.1	Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, баримтын бүрдэл хангах талаар	12
3.2	Өр төлбөрийг барагдуулах талаар.....	13
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	14
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	15
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	16
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18

1 Аудитын гэрчилгээ



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ
АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН
ДАРГА Я.САНЖМЯТАВ ТАНАА

2017.04.25 № 774

танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан "Санхүүгийн тайлангийн аудитын журам"-ын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорилоор олж авсан нотлох зүйлс санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

\\10.10.10.20\Bichig_Kherel\Yawsan_Bichig\2017\0425SAG43.Docx

070242

Аудитаар батлагдсан төсөвт тусгаагүй 3.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг удирдлагын тушаал шийдвэргүйгээр худалдан авсан, ажиллагсадтай холбоотой 69.8 сая төгрөгийн өр төлбөр нь тайлант онд үүссэн байгаа нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг эс тооцвол Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн, шударга илэрхийлэгдсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга Я.Санжмятав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, төсвийн гүйцэтгэл, системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5 дахь заалт, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 4 дүгээр сарын 10-наас 2017 оны 4 дүгээр сарын 20-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 4 дүгээр сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Н.Золзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын 2017 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 45 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь “Монгол Улсын нутаг дэвсгэрт улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгаж, нэр төрийг нь сэргээх, тэдэнд нэг удаагийн нөхөх олговор олгох, улс төрийн хэлмэгдүүлэлтийн бусад үр дагаврыг арилгахтай холбогдсон харилцааг зохицуулах” зорилго бүхий төрийн захиргааны байгууллага юм.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлийн ажлыг хариуцан гүйцэтгэдэг. Үүнд:


- Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажлыг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах
- Хэлмэгдэгсэд, тэдний гэр бүл, ач, зээ нарт нөхөх олговор олгох
- Хэлмэгдэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх, нэр төрийг сэргээх
- Хэлмэгдэгсэд болон нөхөн олговрын мэдээллийн нэгдсэн сан байгуулах
- Хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бусад шийдвэрээр даалгасан бусад үүргийг биелүүлэх.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь үндсэн үйл ажиллагаагаа “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хууль”, “Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дүрэм”, “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн биелэлтийг зохион байгуулах журам”, “Нөхөн олговор олгох, түүнийг бүртгэх, тайлан гаргах журам”, санхүү, төсвийн талаарх үйл ажиллагаагаа Монгол Улсын “Төсвийн тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” зэрэг хуулиудын хүрээнд явуулж байна. “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хуулийн нэмэлт өөрчлөлт оруулахаар төсөлд нэмэлт өөрчлөлт оруулах шатанд явагдаж байна.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бүтэц нь босоо тогтолцоотой түүний харьяанд аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны салбар комиссууд, орон тооны бус хэвлэл, мэдээллийн алба, орон тооны ажлын алба тус тус ажилладаг. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бүтэц бүрэлдэхүүнийг бүдүүвчээр /схемээр/ харуулбал:

А.УЛСЫН КОМИССЫН БҮТЦИЙН БҮДҮҮВЧ



2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 5 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 6 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-З/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад 2015 онд боловсруулж баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн зарим зүйл заалт Сангийн яамнаас 2016 онд авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, журам заавартай нийцэж байна. Гэвч дараах асуудлыг Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт дэлгэрэнгүй тусгах нь зүйтэй. Үүнд:

- Санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх тухай Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан журам, маягт аргачлалтай холбоотой асуудал;
- Төсвийн орлого, зарлагын эдийн засгийн ангилалтай холбоотой асуудал;
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас шинээр гарсан бодлого шийдвэртэй холбоотой асуудал зэрэг болно.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс нь бүтэц, орон тоо, үйл ажиллагааны цар хүрээнээс шалтгаалан дотоод аудитын нэгж ажиллуулаагүй байна.

2.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын төсөвт 2 хөтөлбөр, түүний хүрэх үр дүнгийн зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж урсгал зардалд дээрх хуулиар 475.3 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх зарим мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 463.4 сая төгрөг буюу 97.5 хувьтай байгаа нь Сангийн яам улс орны эдийн засгийн хүндрэлтэй байдлын улмаас төлөвлөсөн зарим зардлын эрхийг хязгаарлах бодлоготой холбоотой 11.9 сая төгрөгөөр дутуу санхүүжүүлснээс шалтгаалжээ.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд урсгал зардал 11.9 сая төгрөг буюу 2.5 хувиар, урсгал шилжүүлэг 7.1 сая төгрөг буюу 3.2 хувиар хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын дарга төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг "shilendans.gov.mn" цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс өөрийн цахим хуудсанд ил тод байдал цэсээр дамжуулан “shilendans.gov.mn” цахим хуудсанд нэвтэрч дараах мэдээллийг нээлттэйгээр тухай бүр авах боломж бүрдүүлсэн байна.

1. Дараа жилийн төсвийн төсөл (бүтэн жилээр)
2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт (бүтэн жилээр, хагас жилээр, улирал бүр, сар бүр)
3. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт (тухай бүр)
4. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагааны орлогоос давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
5. Хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалтын тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
6. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ (тухай бүр)
7. Санхүүгийн тайлан (бүтэн жилээр, хагас жилээр)
8. Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт (бүтэн жилээр)
9. Байгууллагын батлагдсан төсөв (бүтэн жилээр)

Дээрх мэдээллийг нийтэд ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Үндэсний аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2016 оны байдлаар нийцлийн аудит 2 удаа хийхэд Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисстой холбоотой зөрчил дутагдал илрээгүй байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 5 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 8 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Төсвийг зориулалтын дагуу зарцуулах, баримтын бүрдэл хангах талаар

Тайлант хугацаанд эд хогшил худалдан авах зардлын төсөв батлагдаагүй байхад урсгал засвар болон бичиг хэргийн зардлын төсвөөс зориулалт бус, удирдлагын тушаал шийдвэргүй 3.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Анхан шатны баримтын бүрдэл болсон ажил гүйлгээг бүртгэж байх, төсвийг зориулалтын дагуу зарцуулж байх талаар зөвлөмж өгөх

2.9.2 Урьдчилж төлсөн зардлаар бүртгэх талаар

2017 оны ном хэвлэлийн зардлын 0.2 сая төгрөгийг шууд зардалд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн “үнэн зөв” байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Урьдчилж төлсөн төлбөрөөр бүртгэж, энэ дүнгээр үр дүнг нэмэгдүүлэх бичилтийг хийж аудитын явцад залруулав.

2.9.3 Ажиллагсадтай холбоотой өр төлбөрийн талаар

Санхүүгийн тайлангаар ажиллагсадтай холбоотой 71.0 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй байгаа нь захиргааны хэргийн шүүхийн шийдвэрээр үүссэн ажлаас үндэслэлгүй халагдсан хүмүүст олгох нөхөн олговор байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Өр төлбөрийг барагдуулах зөвлөмж өгөх

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй боловч Засгийн газрын авто баазтай тооцоо хийж баталгаажуулаагүй илүү цагийн төлбөр төлсөн тухай асуудлыг Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын удирдлагад асуудлын бүртгэлээр баталгаажуулан танилцуулсан болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох хэлмэгдэгсдийн нөхөн олговор, орон сууцны дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын 171.5 сая төгрөгийн зарцуулалтыг аудитаар үзсэн боловч үндэслэл, бичиг баримтын бүрдлийг үзээгүй болно. Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй өөр эрсдэлтэй асуудал гараагүй болно.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 74.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн байна. Эдгээр зөрчлийг асуудлын бүртгэлд нэгтгэж, баталгаажуулсан болно.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар итгэл үзүүлж “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын төсвийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 557.7 сая төгрөг бөгөөд түүний 2 хувиар тооцож 11.2 сая төгрөгөөр материаллаг байдлын түвшинг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитаар илэрсэн алдаа зөрчил нь материаллаг түвшингээс давсан ба төсвийг зориулалт бус, удирдлагын тушаал шийдвэргүй зарцуулж 3.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, ажиллагсадтай холбоотой 69.8 сая төгрөгийн өр төлбөр тайлант онд үүссэн байгаа нь Төсвийн тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байгаа тул “Хязгаарлалттай” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон Дотоод аудитын албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

3.1 ТӨСВИЙГ ЗОРИУЛАЛТЫН ДАГУУ ЗАРЦУУЛАХ, БАРИМТЫН БҮРДЭЛ ХАНГАХ ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд эд хогшил худалдан авах зардал батлагдаагүй байхад урсгал засвар болон бичиг хэргийн зардлын төсвөөс 3.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, мөн хөрөнгө бэлтгэх удирдлагын тушаал шийдвэргүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлангийн бодит байдлын тухай мэдэгдэлтэй зөрчилдөж байгаа бөгөөд дараах батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Үүнд:

Үнэн зөв байдал - Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайланд тусгасан ажил гүйлгээ, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн болон түүнийг зохицуулж буй хууль тогтоомжуудтай нийцэж байх

ҮАГ-ын зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-г мөрдөж, анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-ыг мөрдөж, төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

3.2 ӨР ТӨЛБӨРИЙГ БАРАГДУУЛАХ ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №2
--	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тус төсөв захирагч нь ажиллагсадтай холбоотой 71.0 сая төгрөгийн өр төлбөрийг толилуулсны 69.8 нь тайлант онд үүссэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийг мөрдөж, төсвийн авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 12 дугаар сарын 01-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх

Эрсдэлүүд

Найдваргүй өр үүсэх, төсвийн ачаалал нэмэгдэх, төсвийн өр нэмэгдэх

Төсвийн захирагчийн хариу

Зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлнэ.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ	2015 ОНЫ 12-Р САРЫН 31	2016 ОНЫ 12-Р САРЫН 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,730.1	14,507.0
МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.1	-
УРЬДЧИЛГАА	-	208.4
БАРАА МАТЕРИАЛ	19,730.0	14,296.6
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	45,925.0	35,348.8
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	45,925.0	35,348.8
Биет хөрөнгө	36,925.0	29,598.8
Биет бус хөрөнгө	9,000.0	5,750.0
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	65,655.1	49,855.7
НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,154.5	70,922.9
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,154.5	70,992.9
Өглөг	1,154.5	70,992.9
ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	64,500.5	(21,137.2)
Засгийн газрын хувь оролцоо	64,500.5	(21,137.2)
Хуримтлагдсан үр дүн	13,429.3	(72,208.4)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	831.8	831.8
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	65,655.1	49,855.7

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН /1/	485,795.7	471,837.4
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,396.1	-
Нийтлэг татварын бус орлого	8,396.1	-
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	477,399.7	471,837.4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН /1/	485,759.5	557,475.1
УРСГАЛ ЗАРДАЛ	485,759.5	557,475.1
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	336,188.3	332,625.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,377.0	230,327.2
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,104.5	20,050.9
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,535.7	17,902.4
Хангамж, бараа материалын зардал	15,271.0	22,615.0
Эд хогшил, урсгал засварын зардал	3,317.8	3,375.8
Томилолт, зочны зардал	31,567.2	4,155.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	40,658.3	18,084.2
Бараа үйлчилгээний бусад зардал	31,356.9	16,114.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,571.2	224,850.1
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН /3=1+2/	36.2	(85,637.7)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (6=3+4-5)	36.2	(85,637.7)

4.3 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцоо	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,464.4		64,464.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	26,705.5		26,705.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	91,169.8		91,169.8
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(26,705.5)		(26,705.5)
	36.2		36.2
Тайлант үеийн үр дүн 2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	64,500.5		64,500.5
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	64,500.5		64,500.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	64,500.5		64,500.5
	(85,637.7)		(85,637.7)
Тайлант үеийн үр дүн 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(21,137.2)		(21,137.2)

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

Тайлангийн үзүүлэлт	2015 оны 12-р сарын 31	2016 оны 12-р сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН /1/	477,714.7	477,625.2
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	315.0	2,493.0
Нийтлэг татварын бус орлого	315.0	2,493.0
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТЫН ОРЛОГО	477,399.7	475,132.2
НИЙТ ЗАРДАЛ БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	470,985.3	474,488.6
УРСГАЛ ЗАРДАЛ	470,985.3	474,488.6
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	321,414.1	246,343.7
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	182,377.0	163,097.8
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,104.5	16,087.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12,535.7	17,902.4
Хангамж, бараа материалын зардал	32,782.8	17,943.3
Эд хогшил, урсгал засварын зардал	3,317.8	4,968.8
Томилолт, зочны зардал	31,882.2	4,506.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,899.3	19,304.2
Бараа үйлчилгээний бусад зардал	514.8	2,533.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	149,571.2	228,144.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3=1-2)	6,729.4	3,136.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН /5/	6,729.4	3,136.6
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,729.4	3,136.6
Дотоод эх үүсвэрээр	6,729.4	3,136.6
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(6,729.4)	(3,136.6)
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.1	(0.1)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.1	-

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мян.төг/

КОД	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН	ЗӨРҮҮ	ХУВЬ
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,297.40	463,419.2	11,878.2	97.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	475,297.40	463,419.2	11,878.2	97.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	251,073.30	246,313.0	4,760.3	98.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,168.90	163,097.8	71.1	100.0
210101	Үндсэн цалин	129,683.10	129,316.5	366.6	99.7
210102	Нэмэгдэл	-	-	-	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,187.40	6,507.4	680.0	90.5
210104	Урамшуулал	-	-	-	-
210105	Гэрээт ажлын хөлс	26,298.40	27,274.0	(975.6)	103.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,087.40	16,087.4	-	100.0
210201	Тэтгэврийн даатгал	11,357.40	10,231.6	1,125.8	90.1
210202	Тэтгэмжийн даатгал	946.00	723.9	222.1	76.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,182.50	1,480.0	(297.5)	125.2
210204	Ажилгүйдлийн даатгал	236.50	723.9	(487.4)	306.1
210205	Эрүүл мэндийн даатгал	2,365.00	2,927.9	(562.9)	123.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,916.90	17,902.4	14.5	99.9
210304	Байрны түрээс	17,916.90	17,902.4	14.5	99.9
2104	Хангамж, бараа материалын зардал	18,428.40	18,039.7	388.7	97.9
210401	Бичиг хэрэг	4,180.60	4,180.2	0.4	100.0
210402	Тээвэр, шатахуун	10,681.10	10,760.8	(79.7)	100.7
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,566.70	3,098.7	468.0	86.9
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,473.90	5,741.7	2,732.2	67.8
210604	Урсгал засвар	8,473.90	5,741.7	2,732.2	67.8
2107	Томилолт, зочны зардал	4,597.90	4,506.4	91.5	98.0
210702	Дотоод албан томилолт	4,597.90	4,506.4	91.5	98.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,928.90	18,404.2	1,524.7	92.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,428.90	15,904.2	1,524.7	91.3
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,500.00	2,500.0	-	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,471.00	2,533.2	(62.2)	102.5

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын даргын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,300.00	2,297.8	2.2	99.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	171.00	235.4	(64.4)	137.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	224,224.10	217,106.1	7,118.0	96.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	224,224.10	217,106.1	7,118.0	96.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,327.00	20,327.0	0.0	100.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	178,544.00	171,565.0	6,979.0	96.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	25,353.10	25,214.2	138.9	99.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	475,297.40	463,419.1	11,878.3	97.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	475,297.40	463,419.1	11,878.3	97.5
310001	Улсын төсвөөс санхүүжих	475,297.40	463,419.1	11,878.3	97.5
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО				
610001	Төсвийн байгууллага	1	1		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО				
620001	Удирдах ажилтан	1	1		
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10		